



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 590

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуйн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 11 нэрийн, нийт 315,935,943.04 (гурван зуун арван таван сая есөн зуун гучин таван мянга есөн зуун дөчин гурван төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор Б.Баасансүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу байгууллагын дансанд төвлөрүүлэх;

2.3.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4.Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002409
27-r_huraldaah.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 11 дугаар сарын 28-ны өдрийн
530 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, улсын болон хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуриятлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Үр тарианы комбайн	2009-12-01	35,000,000.00	35,000,000.00	-	-	4,000,000.00
2	Авто зам индүүдэгч машин	2009-12-01	17,210,395.00	17,210,395.00	-	-	3,000,000.00
3	Олон гүйдэлт трактор, 40-69 УН	2009-12-01	25,622,758.04	25,622,758.04	-	-	3,500,000.00
4	Фургон машин УАЗ, 26-10 УНБ, 90495887	2009/2009	16,500,000.00	16,500,000.00	-	-	4,000,000.00
5	Цемент зуурагч машин	2009-12-01	7,580,395.00	7,580,395.00	-	-	2,000,000.00
6	Автобус том /XIAMEN GOLDEN DRAGON/, 20-04 УНС, LL3BECDH5BA012002	2011/2011	85,262,000.00	85,262,000.00	-	-	8,000,000.00
7	Фургон машин УАЗ, 50-04 УН38 374100B0452171	2011/2011	20,600,000.00	20,600,000.00	-	-	4,500,000.00
8	Суудлын машин KIA SPORTAGE, 50-04 УН3, KNAJE55125O057311	2006/2011	19,200,000.00	19,200,000.00	-	-	4,500,000.00
9	Автобус жижиг /XIAMEN GOLDEN DRAGON/ 30-04 УНС, LL3BCADE2BA002933	2011/2011	38,804,000.00	38,804,000.00	-	-	4,000,000.00
10	Суулдын автомашин KYRON, 10-95 УНП, KPTSKA1KXCP162481	2012/2012	46,000,000.00	46,000,000.00	-	-	5,500,000.00
11	Замын нөхөөс битүүлэгч	2009-12-01	4,156,395.00	4,156,395.00	-	-	1,500,000.00
	НИЙТ ДҮН		315,935,943.04 (гурван зуун арван таван сая есөн зуун гучин таван мянга есөн зуун дөчин гурван төгрөг дөрвөн мөнгө)	315,935,943.04 (гурван зуун арван таван сая есөн зуун гучин таван мянга есөн зуун дөчин гурван төгрөг дөрвөн мөнгө)			44,500,000.00 (дөчин дөрвөн сая таван зуун мянга)